

**2019 ОНЫ 5 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 7 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ/ мэдээ ирүүлсэн.

**Нэг. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:**

2019 оны 5 дугаар сард СЭМҮТ, ЭХЭМҮТ амбулаторийн хүлээгдэлгүй байна. УНТЭ 687, УХТЭ 203, УГТЭ 58, ХСҮТ 368 хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УНТЭ-ийн амбулаторийн 12 кабинетэд нийт 687 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд:

- Бөөрний кабинет 53 хүлээгдэл
- Зүрх судасны кабинет 67 хүлээгдэл
- Мэс заслын кабинет 3
- Уушигны кабинет 4 хүлээгдэл
- Мэдрэлийн кабинет 150
- Нүдний кабинет 137
- Нүдний даралтын кабинет 32
- Чих хамар хоолойн кабинет 47
- Булчирхай судлалын кабинет 28
- Урологийн кабинет 2
- ХБЭС-ын кабинет 113
- Хэрх үе судлалын кабинет 51 хүлээгдэл тус бүр 2-7 хоногийн хугацаатай хүлээсэн байна.

УХТЭ-т нийт 10 кабинетэд 203 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд:

- Бөөр судлалын кабинет 5
- Зүрх судасны кабинет 17
- Уушигны кабинет 1
- Мэс заслын кабинет 2
- Мэдрэл судлалын кабинет 40
- Нүдний даралтын кабинет 23
- Чих хамар хоолойн кабинет 4
- Булчирхай судлалын кабинет 25
- Хоол боловсруулах эрхтэн судлалын кабинет 60

- Эмэгтэйчүүдийн кабинет 26 үйлчлүүлэгч тус тус 2-3 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 12 кабинетэд 218 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-ийн зүрх судасны кабинетэд 12, мэдрэлийн кабинетэд 10, чих хамар хоолойн кабинетэд 4, хоол боловсруулах эрхтэн системийн кабинет 15, мэдрэлийн мэс заслын кабинет 4 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 14 кабинетэд 390 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.


ХСҮТ-ийн амбулаторийн 10 кабинетэд нийт 368 үйлчлүүлэгч үйлчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд:

- Зүрх судасны кабинет 17
- Мэс засал 32
- Элэг цөс нойр булчирхайн кабинет 53
- Толгой хүзүүний мэс заслын кабинет 47
- Эмэгтэйчүүдийн мэс заслын кабинет 75
- Цээжний хөндийн мэс заслын кабинет 53
- Гепатологийн кабинет 18
- Туяа эмчилгээний кабинет 1
- Хими эмчилгээний кабинет 43
- Сэргээн засах кабинет 1
- Ангиографийн кабинет 28 үйлчлүүлэгч тус бүр 2-7 ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 105 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн 2019 оны 5-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



ХСҮТ-ийн 5-р сарын амбулаторийн хүлээгдлийг  
үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



### Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2019 оны 5 дугаар сард УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны тасгуудад 817 хүлээгдэл бүртгэгдсэн байна. өдөртөө үйлчлүүлсэн 385 үйлчлүүлэгч байна.

УНТЭ-т оношлуулахаар 378 үйлчлүүлэгч 2-15 түүнээс дээш хоног хүлээгдэлтэй байна.

Үүнд:

- Рентген зураг 144
- Хэвлийн эхо 113
- Тархины цахилгаан бичлэг 22
- Допплерографи 39
- Захын судасны ЭХО 3
- Бүдүүн гэдэсний дуран 10
- Зүрхний ачаалалтай сорил 2
- MRI 1
- Урологийн оношилгооны дуран 44 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 түүнээс дээш хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.

УХТЭ-т оношлуулахаар 172 үйлчлүүлэгч 2-15 түүнээс дээш хоног хүлээгдэлтэй байна. Үүнд:

- Рентген зураг 50
- Зүрхний цахилгаан бичлэг 12
- Хэвлийн эхо 76
- Ходоодны дуран 18
- Холтер 1

- Допплерографи 15 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 түүнээс дээш хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 101 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т оношлуулахаар 45 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

Үүнд:

- Рентген зураг 12
- Зүрхний цахилгаан бичлэг 28
- Хэвлийн эхо 5 үйлчлүүлэгч тус бүр 2-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

Өдөртөө үйлчлүүлсэн 88 үйлчлүүлэгч байна.

ХСҮТ-д анх удаа оношлуулахаар дугаар авсан 294 үйлчлүүлэгчээс өдөртөө үйлчлүүлсэн 80 үйлчлүүлэгч, 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй 177, 2-6 хоногийн хүлээгдэлтэй 26 үйлчлүүлэгч байна. Нийт хүлээгдэл 199 байна.

Үүнд: Бүдүүн шулуун гэдэсний дуран 1 үйлчлүүлэгч, ходоодны дуран 21, хэвлийн ЭХО 105, зүрхний цахилгаан бичлэг 30, рентген харалт 42 үйлчлүүлэгч тус бүр 2-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.


Өдөртөө үйлчлүүлсэн 80 үйлчлүүлэгч байна.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 197 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 116 өдөртөө, 61 үйлчлүүлэгч 1 хоног, 20 үйлчлүүлэгч 2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Өдөртөө үйлчлүүлсэн 116 үйлчлүүлэгч байна.

ЭХЭМҮТ-д оношилгооны хүлээгдэлгүй байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн оношлогооны кабинетийн 5-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



## Гурав. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдэл:

2019 оны 5 дугаар сард УНТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй.

УХТЭ, УГТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн.


Лабораторийн нийт хүлээгдэл 1563, өдөртөө үйлчлүүлсэн 412 үйлчлүүлэгч байна.

УХТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 1405 үйлчлүүлэгч 2-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 110, шээсний ерөнхий шинжилгээ 113, биохими 998, бактериологийн шинжилгээ 61, иммунологийн шинжилгээ 32, сериологийн шинжилгээ 71, коагулограммын шинжилгээ 20 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 156 үйлчлүүлэгч 2-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 78, биохимийн шинжилгээ 68 үйлчлүүлэгч, иммунологи 10 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Шээсний ерөнхий шинжилгээ серологи, цитологи, иммунологи коагулограммын шинжилгээнүүд хүлээгдэлгүй байна.

Өдөртөө үйлчлүүлсэн 209 үйлчлүүлэгч байна.

УХТЭ, УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 2019 оны 5-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



## **Дөрөв. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

2019 оны 5 дугаар сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ бүртгэн мэдээлсэн. Нийт хүлээгдэл 555 үйлчлүүлэгч хүлээж хэвтэн эмчлүүлсэн байна. ЭХЭМҮТ, УНТЭ-ийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэлгүй байна.

УХТЭ-т 5-р сард нийт 206 үйлчлүүлэгч 3 хоногоос 30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Бөөрний тасагт 22, зүрх судасны системийн тасаг 23, мэс заслын тасагт 69, мэдрэлийн тасагт 15, чих хамар хоолой 51, уламжлалт эмчилгээний тасагт 9, хоол боловсруулах эрхтэн системийн тасагт 17 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т 5-р сард нийт 31 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс: Мэдрэлийн тасагт 5, мэдрэлийн мэс засалд 26 үйлчлүүлэгч тус тус 3-30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

ХСҮТ-д 5-р сард нийт 277 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд 3-6 хоногийн хүлээгдэлтэй 71 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 109 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 87 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 10 үйлчлүүлэгч байна. Ерөнхий мэс заслын тасаг 6, элэг цес нойр булчирхайн тасаг 40, хөнгөвчлөх эмчилгээ 24, хими эмчилгээ 149, ангиограф 58 үйлчлүүлэгч 3-30 хоног хүлээж үйлчлүүлсэн байна

ХСҮТ нь яаралтай тусламжаар өдөрт дунджаар 10 өвчтөн ирдэг, нийт ирж буй үйлчлүүлэгчдийн 98% нь хорт хавдрын хожуу шатандаа орсон өвчтөнүүд байдаг ба үүнээс хэвтэх шаардлагатай өвчтөнүүдийг хөнгөвчлөх болон бусад мэс заслын тасгуудад хэвтүүлдэг учир орны зөрүүтэй байдал үүсдэг.


Химийн тасгаар өвчтөн 14-21 хоногийн давтамжтай “товлолт” эмчилгээнд хамрагддаг тул хүлээгдэлтэй харагдаж байна.

Ангиографийн тасаг нь өдөрт дунджаар 10 өвчтөнд ажилбар хийдэг ба тус тасгийн дундаж ор хоног 1.6 тул ажилбар хийлгэхээр хүлээж буй өвчтөний тоо их байна.

СЭМҮТ-ийн 5-р сард стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 41 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна.

Үүнд: 7 үйлчлүүлэгч 3-6 хоног, 8 үйлчлүүлэгч 7-14 хоног, 26 үйлчлүүлэгч 15-30 хоногийн хугацаанд нийт 84 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

СЭМҮТ-ийн неврозын тасгийн хүлээгдэл (2019 оны 5 сар):



**Тав. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

НЭМГ-ын харьяа 8 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн дотор 118, Хан уул дүүргийн эрүүл мэндийн төвийн дотор 57, ЧДЭМТ-ийн дотор 59, БГДЭМТ-ийн дотор 52, БЗДНЭ-ийн дотор 253, ахмадын эмнэлэг 125 үйлчлүүлэгч тус бүр 3-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 5-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.

**Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 5 сарын хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийн мэдээ**

№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	5 сар										
			СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	ХУД НЭ	СХД НЭ	Наркологийн эмнэлэг
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	70	4	0	4	17	42	0	0	0	0	0
		1-3 хоног		3		4		2					
		3-6 хоног	8	1			5	9					
		7-14хоног	31				6	31					

		15-30 хоног	31				6						
		1 сараас дээш											
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	118	57	59	10	11	41	253	0	0	0	0
		1-3 хоног		19	36			3	56				
		3-6 хоног	9	20	18	2	8	19	57				
		7-14хоног	23	16	5	7	2	19	45				
		15-30 хоног	86	2		1	1		75				
		1 сараас дээш							20				
4	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	125	0	0	0	0	14	0	0	0	0	0
		1-3 хоног	18					7					
		3-6 хоног	15					7					
		7-14хоног	38										
		15-30 хоног	54										
		1 сараас дээш											
5	Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног											
		3-6 хоног											
		7-14хоног											
		15-30 хоног											
		1 сараас дээш											
6	Хавдар	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног											
		3-6 хоног											
		7-14хоног											
		15-30 хоног											
		1 сараас дээш											
7	Наркологийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	153
		1-3 хоног											29
		3-6 хоног											24
		7-14хоног											81
		15-30 хоног											19
		1 сараас дээш											


Нийслэлийн түргэн тусламжийн төвд 5-р сард 25949 дуудлага бүртгэгдсэний 37.1%-ийг 0-20 минутад, 35.8%-ийг 21-40 минутад, 17.6%-ийг 41-60 минутад, 9.5 %-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Түргэн тусламжийн төвийн 5 дугаар сарын тусламж үйлчилгээний хүлээгдлийг өмнөх сартай харьцуулахад 1 цагаас дээш хугацаанд очсон дуудлага 1.9%-иар



буурсан, хамгийн бага хугацаанд \0-20 минут\ хүрч үйлчилсэн тохиолдол 3.2%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2019 оны 1-5 саруудад ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ  
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА